


Геологийн мэдээллийн каталоги системийг нэвтрүүлнэ



Б.Ганбалр / ЗГМО

Б.Мөнх
ЗГМ

Ашигт малтмал, газрын тосны газрын Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв энэ оны дөрөвдүгээр улирлаас эхлэн Монгол Улсын геологийн мэдээллийн каталоги систем ашиглах гэж байна. Геологийн мэдээ, мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэн, хэрэглэгчдэд түргэн шуурхай, бодитоор хүргэх зорилтын хүрээнд энэхүү шинэчлэлийг хийж байгаа аж. Геологийн мэдээллийн каталоги систем буюу МонGeoКат нь эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд

буй геологийн мэдээллийн хураангуйг хэрэглэгчдэд хүргэх зорилготой. Энэхүү систем нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд геологийн мэдээллийн үүсвэрийн мэдээллийг өгөх юм.

Системийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг нь цахим сүлжээний орчинд орон зайн хайлт хийх боломжтой төдийгүй газарзүйн мэдээллийн систем. Уг систем нь орон зайн дүн шинжилгээ хийдэг ArcGIS программд суурилжээ. Хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг нь геологийн мэдээллийн тухай хураангуйг түдхүүр үгээр хайх метадата-каталоги систем. Энэ нь орон зайн мэдээллийн каталоги хийхэд хэрэглэдэг GeoNetwork программд

суурилсан метадата гэдэг нь мэдээллийн талаарх хураангуй мэдээ. Тухайн мэдээллийг хэн, хэзээ, хаана, хэрхэн, ямар зорилгоор бэлтгэсэн талаар энд өгүүлэх юм.

Хэрэглэгч МонGeoКат системээс хоёр төрлийн мэдээлэл хайх боломжтой. Тодруулбал, веб ГМС-гийн орчинд орон зайн хайлт хийж, төрөл бүрийн суурь зураг, жижиг, дунд масштабын геологийн зургууд, сансрын зураг, ашигт малтмалын ордуудын байршил болон бусад мэдээлэл үүнд багтжээ. Метадата-каталоги системээс олон сонголтот хэрэгсэл ашиглаж хайлт хийж, мэдээллийн тухай хураангуй буюу уг мэдээллийн зохиогч, эзэмшигч, хэмжээ,

хэлбэр, хэлний сонголт, бусад мэдээлэлтэй хэрхэн холбогддог, хайгуултай холбоотой мэдээлэл, байр зүйн холболттой эсэх, хандалтын зэрэглэл болон бусад мэдээлэл оржээ. Энэхүү системийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газрын Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан байгуулах ажлын төлөвлөгөөний хүрээнд ажил хэрэг болгож байна.

Энэхүү системийг Австралийн Засгийн газар болон Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн тусламжаар “Оюуны цоморлиг импекс” компани хөгжүүлжээ.